

Миний баптисмын гэрээ

Гэрээ бол бидний Тэнгэрлэг Эцэгтэй хийдэг амлалт юм. Бидний баптисм хүртэхдээ хийхээр амладаг гурван зүйлийн талаар уншаарай. Дараа нь чи баптисмын гэрээгээ сахихдаа юу хийж болох талаараа бичээрэй.

Үргэлж Есүс Христийг санах

Элена бусдыг хэн нэгэнд таагүй хандаж байхыг харсан үедээ Есүсийн хийх байсан зүйлсийг боддог.

Би Есүсийг хэрхэн санаж чадах вэ:

“Үргэлж түүнийг сана” (Моронай 4:3).



Түүний нэрийг өөр дээрээ авах.

Нана найздаа Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд харьяалагддагаа хэлэв.

Түүний нэрийг өөр дээрээ авах нь ямар утга учиртай вэ:

“Өөрсдөдөө [Есүс Христ]-ийн нэрийг ав” (Моронай 4:3).



Түүний зарлигуудыг дагах

Жэймс муухай үг хэллэг, дүрс бүхий бичлэг үзэхгүй байхыг сонгосон.

Миний дагаж болох зарлиг:

“Түүний зарлигуудыг дага” (Моронай 4:3).



ГЭРЭЭГЭЭ САХИХ НЬ

Баптисмын гэрээгээ сахих зарим арга замыг энд оруулав. Үүнд:

Хүмүүст туслах

Акио дүүдээ тооны даалгавраа хийхэд нь туслав.

Би хэнд тусалж чадах вэ:

“Нэг нэгнийхээ ачааг хөнгөн байж болохын тулд . . . үүрэлц” (Мозая 18:8).



Буруу юм хийсэн үедээ наманчлах

Иса эгчдээ эелдэг бус зүйл хэлснийхээ дараа Тэнгэрлэг Эцэгт хандан залбирчээ. Тэгээд тэр эгчээсээ уучлал гуйжээ.

Би хэрхэн наманчилж болох вэ:

“Наманчилж мөн дахин төр” (Алма 5:49).



Бусдыг тайтгаруулах

Лукас өвөө нь нас бараад удаагүй байсан найзындаа очив.

Би хэн нэгнийг хэрхэн тайтгаруулах вэ:

“Тайтгарал хэрэгтэй тэднийг тайтгаруул” (Мозая 18:9).



ЧИНИЙ ГИШҮҮНИЙ БАТАЛГАА

Баптисмын чинь дараа санваарын удирдагч чиний толгой дээр гараа тавих болно.

Тэр чамайг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүнээр баталж, Ариун Сүнсийг хүлээн авна уу хэмээн адислах болно (Сургаал ба Гэрээ 33:15-ыг үзнэ үү).

ТЭНГЭРЛЭГ ЭЦЭГ ЧАМД ЮУ АМЛАДАГ ВЭ?

Биднийг баптисм хүртэж, гишүүнээр батлуулах үед Тэнгэрлэг Эцэг бидэнд Өөрийнх нь Сүнс бидэнтэй үргэлж хамт байх болно хэмээн амладаг. Ариун Сүнс бидэнд Бурханы хайрыг болон тайтгарал, амар тайвныг мэдрэхэд тусалдаг. Тэрээр мөн биднийг наманчлах үед өршөөгдсөн гэдгээ мэдрэхэд тусалдаг.

Чи ариун ёслолын залбирлыг долоо хоног бүр сонссоноор баптисмынхаа гэрээний талаар илүү ихийг сурч мэдэж чадна (Сургаал ба Гэрээ 20:77, 79).